



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/89

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах (Рашаант сум) зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: - Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: - Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

- Б.Эрдэнэтуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: - О.Буянбат (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: - Б.Бямбасүрэн (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо / Т.Баттулга /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



8323010025